



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 12 өдөр

Дугаар 5/52

Чингис хот

М.Урандолгиог ажлаас чөлөөлж,
Д.Ганболдыг түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3.2, 21 дүгээр зүйлийн 21.1, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дотоод, гадаад харилцаа, шагнал, ёслолын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Урандолгио нь 3 сараас дээш хугацаагаар суралцах болсон тул 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Уг орон тоог нөхөх хүртэлх хугацаанд тухайн албан хаагчийн албан үүргийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Нутгийн захиргааны байгууллагын бодлого, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн Д.Ганболдыг томилсугай.

3. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ж.Гантулга -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд: Д.Ганболд -Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Т.Баямбадулам -Архив бичиг хэргийн эрхлэгч

Т.Баяртуяа - Аж ахуйн нярав

4. М.Урандолгиотой холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч /Э.Ариунтунгалагт/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР